УЛААНБААТАР ХОТ
ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ ОНӨААТҮГ
7037793 СТА5713 9024060648

“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын
захирлын 2025 оны 11 сарын 11
өдрийн А/99 дүгээр тушаалын хавсралт

# АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** | | |
|---|---|---|
| 1. Байгууллагын нэр:<br>**“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ** | 2. Хэлтсийн нэр:<br>**Техник технологийн хэлтэс** | |
| 3. Ажлын байрны нэр: | 3.1 Албан тушаалтны ангилал: | 3.2. Албан тушаалтны зэрэглэл: |
| **Угаалгын оператор** | | |
| 4. Шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр: | Ахлах инженер, Засварын инженер | |
| 5. Шууд харьяалан удирдах албан тушаалтан: | 5.1. Албан тушаалын нэр:<br>Байхгүй | 5.2. Албан тушаалын тоо: |
| 6. Бусад харилцах субъект: | - Харилцагч Төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд<br>- Тус байгууллагын бүх ажилтнууд | |
| Ажлын цаг: | 8 | |
| Ажлын байрны албан ёсны байршил: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 10 дугаар хороо Морингийн даваа, оффиссын байр | |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Хэвийн | |
| Онцгой нөхцөл: | Хамаарахгүй | |

**II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ**

Албан тушаалын зорилго:
Тээврийн хэрэгсэлд угаалгын төхөөрөмжийг ашиглан гадна угаалга хийж, тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглах, галын болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

Албан тушаалын зорилт:
1. Автобусны гадна цэвэрлэгээг хариуцан угаалга цэвэрлэгээ хийх, тоног төхөөрөмж ажиллуулах
2. Автобусны угаалга хийх явцдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг бүрэн хангах
3. Өөрийн эзэмшиж хариуцаж буй өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, байгууллагаас зохион байгуулж буй ажилд сайн оролцох. Бусад үйл ажиллагаа болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэлбэр |
|---|---|---|---|
| | 1. Өглөө ажлын графикийн дагуу ажилдаа угаалгын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг өөрийн биеэр үзэж, шалгах механик, ээлжийн инженерээс засвар үйлчилгээ хийх зааварчилгаа, үүрэг даалгавар авах | Байгууллагын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдана | Г |
| | 2. Ажлын хувцас хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөж, автобус, автомашины гадна талыг угаах болон засвар үйлчилгээ хийх бол хөдөлгүүр, хүч дамжуулах ангийг даралттай усаар шүршиж, угааж, тоог нь ашиглалтын инженерт мэдээлэх | Биелэлтийг бодитой гаргаж хэрэгжилтийг хувь | |
| | 3. Угаалгын байранд өөр хүн оруулахгүй сонор сэрэмжтэй байж, эргэж тойрон, элдэв осол, гэмт хэргээс сэргийлнэ. Ажлын бус цагаар дуудсан үед таксигаар ирж эвдрэлийг засаж, зардлаа санхүүгээс авна | Зорчигчдыг аяа тухтай орчинд үйлчлүүлэх | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | | нөхцөлийг бүрдүүлэх | |
| | 4. Гал, хөлдөлт, усны болон бусад аюул, гэмт үйлдэл гарвал удирдлага, цагдаад утсаар эсвэл бусдаар дамжуулан мэдэгдэж, өөрөө таслан зогсоох арга хэмжээг бололцооны хирээр авах | Хариуцсан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн байдлаар хэмжигдэнэ | |
| | 5. Галын аюулаас сэргийлэх багаж, хорыг байнга бэлэн байлгах | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангагдана | |
| | 6. Байгууллагаас эзэмшүүлсэн эд хөрөнгийг зориулалтын дагуу хайр гамтай эзэмшин бүрэн бүтэн хүлээлгэж өгөх | Ажлын бүтээмж нэмэгдэнэ | |
| | 7. Өөрийн ажлын байрны цэвэр цэмцгэр байдлыг хангаж, хуваарьтай талбайг цэвэрлэн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Зохион байгуулагдсан ажлын хэрэгжилт | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Хэсэг нэгжийн удирдлагаас хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны өдөр тутмын давтан зааварчилгаа авч, танилцсан гарын үсэг зурж ажилдаа орох | Хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журам болон бусад дүрэм журмуудын хэрэгжилт | Г |
| | 2. Угаалга, дулаан, ус хангамж, цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж эвдрэлтэй, дутуу ажилласан бол холбогдох хүмүүст мэдэгдэн, сэлбэг багаж хэрэгсэл авч, өөрийн болон орчны аюулгүй байдлыг хангаж засвар үйлчилгээ хийнэ. Ажиллуулах заавар зөвлөгөө өгч ашиглалтын буруугаас болсон бол санхүүд мэдэгдэн акт бичүүлэх | Осол аваар гарах зөрчил дутагдалгүй болж ажиллах орчны аюулгүй байдал хангагдана | Г |
| | 3. Байгууллага болон албаны зүгээс зохион байгуулж буй олон нийтийн ажил болон цаг үеийн шаардлагаар гарч буй нэмэлт ажлын үед товлосон цаг хугацаа, засварын журмыг хатуу баримталж идэвх санаачилгатай ажиллах | Дээд газрын тогтоол шийдвэр хэрэгжсэн байна. | Г |
| | 4. Байгууллагаас зохион байгуулагдаж байгаа комисс, ажлын хэсгийн гишүүн болсон үед тогтоосон заавар журмын дагуу ажиллах | Үүрэг даалгаврын биелэлтээр үнэлэгдэнэ. | |
| | 5. Хариуцаж буй цех суваг болон гадна орчны хуваарьт талбайн цэвэрлэгээг тогтмол өдөр бүр хийх | Хөдөлмөрийн дотоод журам биелэлт | |
| | 8. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон бусад журам, тушаалыг хэрэгжүүлж мөрдөж ажиллах<br>9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;<br>10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан | Хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж, үндсэн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа бүрэн хангагдана. | Г |

117

| | | | |
|---|---|---|---|
| | бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;<br>11. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;<br>12. Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;<br>13. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;<br>14. Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;<br>15. Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;<br>16. Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах | | |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | | Бүрэн бус дунд түүнээс дээш |
| Мэргэжил | | Шаардахгүй |
| Мэргэшил | | Шаардахгүй |
| Туршлага | | Шаардахгүй |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | Халуун, хүйтэн, чийгтэй нөхцөлд ажиллах чадвартай, эрүүл мэндийн хувьд тэнцэх |
| | | Хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх |
| | Асуудал шийдвэрлэх | Аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгадаг байх |
| | Манлайлах | Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх |
| | Бусад | Багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах |

| IV. АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| **Ажил, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Ажил, албан тушаалын тодорхойлолтыг хянасан:** |
| Техник, технологийн хэлтсийн дарга<br>………………………………… /Д.Сүхбат/ | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга<br>………………………………… /Н.Даариймаа/ |
| **Ажил, албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын захирал<br>………………………………… /Д.Жавхлан/ | |